

ТАВДУГААР АЖЛЫН ХЭСЭГ- 1 дүгээр хуралдаан
 2015 оны 3 дугаар сарын 25- ны 15,00 Сангийн яамны 9 дүгээр давхарын Хурлын
 танхим
 Ирц:

	Албан тушаал	Нэр	Ирсэн/ирээгүй тайлбар
1	Уул уурхайн яамны СБТГ- ын ахлах мэргэжилтэн	Ч.Цогтбаатар	Ирсэн
2	УИХ-ын Тамгын газрын ХҮХ- ийн мэргэжилтэн	С.Тэгшжаргал	Ирсэн
3	Сангийн яамны ТБТГ- ын мэргэжилтэн	У. Мөнхзул	Ирсэн
4	Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч	Н.Алгаа	Ирсэн
5	Эрдэнэт Үйлдвэр ХХК- ийн ХМХ- ийн орлогч дарга	Д.Галбаатар	Өвчтөй
6	Оюутолгой ХХК-ийн ОТХА- ы зөвлөх	Х.Лхамаа	Ирсэн
7	Транспаренси интернэйшл байгууллагын зохицуулагч	Л.Төр-од	Ирээгүй, гадаадад
8	Хүний эрх хөгжлийн төвийн тэргүүн	Г.Уранцоож	Ирээгүй, томилолттой
9	Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны Гүйцэтгэх захирал	Л. Баяраахүү	Ирсэн
10	Монгол нүүрс ассоциацийн Гүйцэтгэх захирал	Т. Наран	Ирээгүй
11	Монголын жонш олборлогчдын холбооны Гүйцэтгэх захирал	Д.Мөнхбазар	Ирээгүй Ирсэн
12	ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч	Ш.Цолмон	Ирсэн

Хуралдааны эхэнд Ажлыг албаны зохицуулагч Ш.Цолмон Эрдэнэт Үйлдвэр ХХК- ийн ХМК- ийн орлогч дарга Д.Галбаатараас ирүүлсэн 5 хуудас санал, тооцоо, судалгааг гишүүдэд тарааж танилцуулсан байна.

Ч.Цогтбаатар- Манай газрын шинэ томилогдох хүртэл энэ хэсгийн ахлагчийн үүргийг гүйцэтгэнэ үү гэсний дагуу өнөөдрийн ажлыг эхлүүлж байна. Манай хэсгийн хариуцаж байгаа асуудал өөрөө нилээд маргаан дагуулдаг, нөгөө талаас компаниудын татварын дарамтыг аль болох бага түвшинд байлгахтай зөрчилдсөн байдаг. Сүүлийн үед ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнэ буурч, орлого муудаж байна. Бид нүүрс, жоншний үнийг гэрээний үнээр тооцх туршилтыг явуулж байгаа бөгөөд үр дүн нь мөд гарах байх гэж найдаж байна. Метал ашигт малтмалын хувьд олон улсын биржийн үнийг баримтлан ажиллахад болж байна. Эрдэнэтийн хувьд энэ асуудлаар асуудал гаргахгүй болж байх шиг, харин Цайрт минерал компани шүүхдээд түүнээс хойш чимээгүй болсон билээ.

Н.Алгаа- Бид энэ асуудлыг олон жил дагнан судалж, нилээд их судалгааны материал, дүгнэлттэй болсон билээ. Ноднин 10 дугаар сард хурал зохион байгуулж, одоо ч гэсэн хурал зохион байгуулахад боломжтой байна. Тэр хурлын зөвлөмжийг гишүүдэд тараах нь зүйтэй байна. Энэ асуудлыг Ашигт малтмалын хуулийн холбогдох заалт, татварын аргачлал,

холбогдох Засгийн газрын тогтоол гээд хэд хэдэн баримт бичгүүдийг тараах нь зүйтэй. Тэр бүрт оруулах саналаа гишүүд Ажлын албанд өгхө хэрэгтэй, түүнийг үндэслэн холбогдох зэрэгцүүлэлтийг гишүүдэд танилцуулж, нэгдсэн нэг ойлголттой болох ёстой.

С.Тэгшжаргал – Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсээс “Эрдсийн бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлалыг боловсронгуй болгох нь” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох байнгын хороодын гишүүд, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулах төлөвлөгөөтэй байгаа. Энэ хэлэлцүүлгийг 4 дүгээр сарын 15-20- ны хооронд зохион байгуулвал ямар вэ гэсэн саналыг дэвшүүлж байна.

Н.Алгаа- Хэд хэдэн илтгэл бэлэн байгаа, гагцхүү яаж танилцуулах вэ гэдгийг зөвлөлдөх шаардлагатай байгаа. Тухайн үед 47 дугаар зүйлд ингэж байх нь зүйтэй гэсэн хэдий ч, хасагдсан байгаа юм. Тогтоол дээр эх үүсвэрийг өөрчлөх, аргачлал дээр юуг юутай жиших зэргийг ойлгомжтой болгохыг санал болгосон.

Ч.Цогтбаатар- Энэ ажлын хэсэг үр дүнгээ Үндэсний зөвлөлдөө танилцуулах нь зүйтэй, УМХ-ын гишүүдэд зориулан хэлэлцүүлэг зохион байгуулбал, буруу ойлгоод ажлыг гацааж мэдэх тул болгоомжтой хандах хэрэгтэй байна. 4 дүгээр сарын 20 гэхэд бүх зүйлээ нэгтгээд Үндэсний зөвлөлд оруулах ажлыг бэлтгэх саналтай байна.

Н.Алгаа- Засгийн газар, компани саналуудаа бэлтгэж, иргэний нийгмийн байгууллагаар санал зөрвөл, хагууллах саналтай байна. Гарсан зөвлөмж материалаа Үндэсний зөвлөлд өгөхөөс гадна УИХ-ын Тамгын газарт бас өгөх нь байна. Гэхдээ дүгнэлт хэлбэртэйгээр өгөх нь зүйтэй. Ер нь 5 дугаар сарын 1- н гэхэд Үндэсний зөвлөлд танилцуулах хэрэгтэй.

Л.Баяраахүү- Ер нь ижил материалтай болох хэрэгтэй байна. Ерөнхий хамрах хэлбэр, хүснэгтээ зөв сонгох нь чухал, үүнийг Ажлын алба сайн хийж өгөх хэрэгтэй байна. 4- 5 холбоо байдаг, өөр өөрийнхөөрөө хийвэл хэцүү болно шүү. Ер нь энэ асуудлын гол шийдэгч нь Сангийн яам бус харин Ууул уурхайн яам баймаар байгааг хэлэх нь зүйтэй байна.

У. Мөнхзул- Сангийн яамнаас энэ аль болох ойлгомжтой болгох, цэгцлэх нь зүйтэй утгаар нь цаашдаа АМНАТ-ын тусдаа хууль байх нь зүйтэй үзэл баримтлалттай байгаа үзэл баримтлалыг боловсронгуй болгоход энэ ажлын хэсэг ажиллаж болно шүүдээ.

Н.Алгаа- Зөвлөмж маань аль болох олон хувилбартай, сэтгэл зүйн дарамтнаас гаргасан, сайн жиших үнэтэй байх хэрэгтэй байна.

Х.Лхамаа- Уул уурхайн салбарт шинэ дэвшил, технолог авчирч байгаа гэдэг утгаар нь зөвлөмж гарах нь зүйтэй.

Л.Баяраахүү- Жиших үнээр тооцоо хийхэд 6 компани зургуулаа хасах дүнтэй гарсан бол гэрээний үнээр тооцоход 3 нь ашигтай гарах зэргээр аргачлалыг өөрчлөх, сайжруулах нь чухалтай харуулж байна.

Ч.Цогтбаатар- Энд ярьж тохирсоны дагуу холбогдох материалуудаа Ажлын албанд ирүүлэхээр тогтов. Жиших үнэтэй холбоотой судалгааг Сангийн яамнаас Ажлын албанд өгөх болов.